



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА Н.ЧИНБАТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.05 № 1/05 ЧАГ-САГ/2013/05-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Оюуны өмчийн газрын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ Үүнд:

Оюуны өмчийн газрын санхүүгийн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 35.3 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 2.5 дахин өссөн бөгөөд үүний 88.5 хувь буюу 30.3 сая төгрөг Худалдаа хөгжлийн банкны 499019150 тоот валютын дансанд байршиж байна. Уг дансаар олон улсын бараа тэмдэгийг баталгаажуулсан гэрээт ажлын орлого хүлээн авдаг байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т “Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна”, 35.3-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх” заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 3.1.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

Төсвийн тухай хуулийг зөрчиж нээсэн харилцах дансыг хааж, төсвийн тухай хуулийн дагуу шийдвэрлэж биелэлтийг 2014 оны 5 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Оюуны өмчийн газрын дарга Н.Чинбат, ерөнхий нягтлан бодогч Д.Чинчулуун нарт хариуцуулав.

АУДИТОР



Л.МӨНХЦАЦРАЛ